



НИЙСЛЭЛИЙН  
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Нийслэлийн Засаг Даргын А/302, А/411 дүгээр захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хорооны 2012 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 13 тоот зөвлөмжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын бохирдлын хяналт, шинжилгээ, үнэлгээний сүлжээг боловсронгуй болгох ажлын хүрээнд физик, химийн хортой нөлөөллийг хянах, хэмжих зориулалт бүхий багаж хэрэгслүүдийг нийлүүлэх зорилгоор “Агаарын чанарт хяналт-шинжилгээ хийх тоног төхөөрөмж нийлүүлэх” АЧА 2012/02/07 тоот дугаартай гэрээт ажлын нийлүүлэлтийн гүйцэтгэлийг протоколоор хүлээж авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Х.Галымбек	/Дэд дарга/
Гишүүд:	Д.Даваадорж	/Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга/
	М.Амарбаяр	/ахлах мэргэжилтэн/
	Г.Даваажаргал	/мэргэжилтэн/
	П.Ариунаа	/Нябо /

2. “Цэцүүх трейд” ХХК-иас техникийн тодорхойлолтод дурьдсан нэр төрлийн барааг зохих журмын дагуу хүлээн авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Х.Галымбек/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



*Don Ч.БАТСАЙХАН*